



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/122

Улаан-Уул

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл
ахуйн улсын үзлэг зохион байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, аймгийн Засаг даргын А/580 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын өмчийн хэлбэр харгалзахгүй хамруулан батлагдсан удирдамж, маягтын дагуу хариуцлагатайгаар 2022 оны 09 дүгээр сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн улсын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Зоригт (Тамгын газрын дарга)

Гишүүдэд: Б.Хүрэлбаатар (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Э.Тогтох (Сургуулийн нийгмийн ажилтан)

Ү.Баттулга (Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан)

С.Бат (Хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогчийн төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Д.Батжаргал (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж тайланг хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Зоригт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201251